



СЭЛЭНГЭ АЙМАГ
ОРХОНТУУЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 24

Баянцогт

Нохой тэжээх, арчлах, золбин нохой
устгахад дагаж мөрдөх журам батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д” дэх хэсэг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.18 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас ТОГТООХ нь:


1.Орхонтуул сумын нутаг дэвсгэрт нохой тэжээх, арчлах, золбин нохой устгахад дагаж мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмын биелэлт, үр дүнг жил бүрийн эцэст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг сумын Засаг дарга /П.Батбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.ЦОГБАЯР



ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ НОХОЙ ТЭЖЭЭХ, АРЧЛАХ, ЗОЛБИН НОХОЙ, УСТГАХАД ДАГАЖ МӨРДӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Орхонтуул сумын хэмжээнд эзэнтэй буюу эзэнгүй нохой өдрөөс өдөрт нэмэгдсэнээс орчныг бохирдуулах, байнгын хамгаалалт уяатай байлгаагүйгээс хүн, мал амьтдыг зуух, гэмтээх, иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах, зөвшөөрөл хяналтгүйгээр тэжээснээс золбин нохой элбэгшиж, улмаар зэрлэгших, халдварт өвчин тараах зэргээр хүн амын эрүүл, аюулгүй байдалд учруулж болзошгүй сөрөг нөлөөг таслан зогсооход энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Нохой тэжээгчийн үүрэг

2.1.Нохой тэжээхийг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нь сумын мал эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, тарилга, туулга хийлгүүлэн гэрчилгээ, пайзыг мал эмнэлгээр дамжуулан нэгдсэн журмаар заавал авна. Нохой үхэх, алга болох, тэрчлэн эзэн солигдох тохиолдолд /худалдах, бэлэглэх/ гэрчилгээнд Мал эмнэлгийн газраар тэмдэглэл хийлгүүлнэ.

2.2.Нохой тэжээгч байгууллага, иргэд нь орон сууц, гэр хорооллын хашаанд тусгай бэлтгэсэн байр, талбайд бат бэх уяатай байлгаж,тэжээж байх.

2.3.Нохой бүхий гэр хорооллын айл өрхүүд нь гадна хаалгандаа өдөр, шөнийн цагаар бусдад харагдахуйц ил тод анхааруулах тэмдэглэгээ хийсэн байна.

2.4.Тэжээвэр нохойг 06-22 цаг хүртэл хугацаанд байнга уяатай байлгах ба бусад цагт хашаан дотор нохой нь хүн мал амьтныг айлгаж гэмтээсэн тохиолдолд нохойн эзэн хариуцахгүй байх.

2.5.Нохойн байр, уяа, идүүр зэргийг тогтмол цэвэрлэж, ариутгуулж байна.

2.6.Нохой тэжээгч нь жил, улирал бүр туулгалтыг харъяалах мал эмнэлгийн газраас тухайлан зарласан хугацаанд хийлгүүлж, энэ тухай тодорхой тэмдэглэлийг нохойн гэрчилгээнд хийлгэж байна. Дээрхи үйлчилгээний зардал нь нохойн хураамжаас төлөгдөнө.

2.7.Нохой өвчилсөн тохиолдолд тухайн эзэмшигч тухайн багийн мал эмнэлгийн байгууллагад хандан холбогдох эмчилгээ хийлгэж, үхсэн тохиолдолд хүүр сэгийг тухайн Мал эмнэлгийн хяналтан доор зөвшөөрөгдсөн цэгт булж устган бүртгэлээс хасуулна.

2.8.Орон сууцанд нохой тэжээж байгаа иргэд нь оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах, дундын өмчлөлийн шат, орц, хонгил, сууцны гаднах 100 метрт тэжээвэр амьтдын үс ноос ялгадсаар бохирдуулахгүй байх, хэрэв бохирдуулбал тухайн эзэн нь цэвэрлэн, тогтоосон цэгт аваачиж хаяж байна.

2.9.Нохой тэжээгч нь төлбөрөө тогтоосон хугацаанд нь төлж барагдуулах ба Орхонтуул сумын ЗДТГ-н нэмэлт санхүүжилтийн дансанд эр нохой жилийн 4000 мянган төгрөг, эм нохой 8000 мянган төгрөгөөр тооцон тухайн оны нэгдүгээр сард багтаан тушаана.

2.10.Нохой тэжээгч нь нохойндоо гэрчилгээ, пайзыг тогтоосон үнээр нь худалдан авах ба нохойн хүзүүвч нь харагдуйц тод улаан өнгийн хэлтэй байна.

Гурав. Нохой эзэмшигчийн эрх

3.1.Нохой тэжээгч нь нохойндоо мал эмнэлгийн үйлчилгээг тогтсон хугацаанд хийлгүүлэх

3.2.Нохой тэжээгч нь энхүү журмын дагуу нохойгоо тэжээж байхад нохойд нь гэмтэл учруулах /устгах/ тохиолдолд тухайн этгээд нөхөн төлбөр төлнө.

Дөрөв. Нохой тэжээгчдэд хориглох зүйл

4.1.Нохойг хамгаалалтгүй байлгаснаас хүн, мал уруулах, эмчилгээ, шинжилгээ хийлгэлгүй нохой тэжээх, бусдад худалдах, шилжүүлэх, золбируулж хаях.

4.2.Мал эмнэлгийн газрын туулгалтанд хамрагдаагүй, пайз, гэрчилгээгүй нохой тэжээх.

Тав. Золбин нохойг устгах талаар

5.1.Золбин нохойг устгах цэгийг баг бүрт байгуулна.

5.2.Гудамж талбайгаар эзэн, хараа хяналтгүй сул яваа болон хүний биед гэмтэл учруулсан нохойг шууд устгаж байна.

5.3. Золбин нохойг Цагдаа, байгаль орчин,ХАА мал эмнэлгийн байгууллагын чанд хараа хяналтан доор устгуулан тогтоосон цэг халдваргүйжүүлэлт хийн булж устгана.

Зургаа. Журмын биелэлтэнд хяналт тавих

6.1.Журмын биелэлтэд ЗДТГ, Багийн Засаг дарга нар, Цагдаагийн алба, ЭМТ-үүд, мал эмнэлгийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

Долоо. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 201 зүйлд зааснаар:

7.1.Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хүний бие махбодийг хөнгөн буюу хүндэвтэр гэмтээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Эрүүл ахуйн тухай хууль шинэчилсэн найруулга 20.1.8 заалтад:

7.2.Нийтийн эзэмшлийн болон үйлчилгээний газар, орон сууцны орчныг нус, шүлс, цэр, тамхины иш, гэрийн тэжээвэр амьтны ялгадсаар бохирдуулах, зориулалтын бус газарт бие засах, хог хаягдлыг ил задгай хаях, шатаахыг хориглоно. Уг журмыг зөрчвөл 20 мянган төгрөгөөр торгуулах юм.

7.3.Энэхүү журмын заалт болон мэргэжлийн холбогдох байгууллагаас тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй иргэдэд эрх бүхий албан тушаалтан хуульд заасан эрхийнхээ дагуу арга хэмжээ авна.